ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын 18 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2026/056/НА-СТА-ТШ3**


Цахим хуудас: www.audit.mn

Дорнод аймаг

2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нармандах
Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг
Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000
Утас: 7058-4203

2026.02.25 № 315

танай ____________-ны №____________-т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
18 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ЭНХЗУЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын 18 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

2126050039

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Хэрлэн сумын 18 дугаар цэцэрлэг нь 2025 онд 5 зорилт, 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг "Хангалттай" буюу 84.9 хувиар үнэлүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **83,230,695.56** | **39,436,189.63** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 47,946,689.56 | 7,168,154.63 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 47,946,689.56 | 7,168,154.63 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 47,946,689.56 | 7,168,154.63 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 35,284,006.00 | 32,268,035.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 199,400.00 | - |
| 35130 | Эм боох материал | 199,400.00 | - |
| **354** | **Хангамжийн материал** | 35,084,606.00 | 32,268,035.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,653,950.00 | 4,009,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 400,000.00 | 400,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 32,030,656.00 | 27,858,535.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,517,381,501.19** | **1,482,131,539.27** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,517,381,501.19 | 1,482,131,539.27 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,447,051,501.19 | 1,411,867,539.27 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,449,172,071.00 | 1,449,172,071.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (120,764,339.40) | (144,917,207.28) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 79,595,176.00 | 82,392,476.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (44,097,116.24) | (47,539,961.60) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 84,141,277.55 | 88,871,639.55 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (41,306,299.92) | (49,426,798.68) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 56,753,515.00 | 56,753,515.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (16,442,782.80) | (23,438,194.72) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 70,330,000.00 | 70,264,000.00 |
| 39301 | Програм хангамж | 660,000.00 | 660,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (330,000.00) | (396,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 70,000,000.00 | 70,000,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,600,612,196.75** | **1,521,567,728.90** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **1,267,721.09** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 1,267,721.09 |
| **413** | **Өглөг** | - | 1,267,721.09 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 1,267,721.09 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,600,612,196.75** | **1,520,300,007.81** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,600,612,196.75 | 1,520,300,007.81 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,600,612,196.75 | 1,520,300,007.81 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,655,522,625.07 | 1,607,089,238.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (54,910,428.32) | (86,789,230.94) |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,600,612,196.75** | **1,521,567,728.90** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **704,625,654.55** | **821,310,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **15,900,454.55** | **1,220,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 15,900,454.55 | 1,220,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 15,705,454.55 | 1,220,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 195,000.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **688,725,200.00** | **820,090,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 665,471,300.00 | 765,787,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 665,471,300.00 | 765,787,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23,253,900.00 | 54,302,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23,253,900.00 | 54,302,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **759,536,082.87** | **908,099,830.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **756,229,186.51** | **906,695,159.66** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 755,829,904.42 | 876,147,358.43 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 537,510,735.74 | 630,054,037.93 |
| 210101 | Үндсэн цалин | 359,120,321.97 | 410,300,033.22 |
| 210102 | Нэмэгдэл | 152,121,964.71 | 161,789,696.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 25,131,283.99 |
| 210104 | Урамшуулал | 26,268,449.06 | 32,833,024.33 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 67,212,400.00 | 79,618,321.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,704,400.00 | 54,416,221.09 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,377,000.00 | 6,300,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,688,500.00 | 3,150,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,688,500.00 | 3,150,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,754,000.00 | 12,601,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,254,617.91 | 23,302,898.77 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,538,416.63 | 8,265,355.03 |
| 210302 | Түлш, халаалт | 7,560,916.28 | 8,829,063.74 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,155,285.00 | 6,208,480.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,625,986.25 | 10,044,221.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,595,150.00 | 1,928,880.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 207,800.00 | 38,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,823,036.25 | 1,599,499.00 |
| 210409 | Бараа материал шилжүүлсэний зардал | - | 6,477,042.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 58,389,825.00 | 65,111,700.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 84,600.00 | 518,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 58,305,225.00 | 64,593,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,468,600.00 | 7,821,350.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,468,600.00 | 7,821,350.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 840,000.00 | 1,230,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 840,000.00 | 1,230,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 58,527,739.52 | 58,964,829.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,072,364.00 | 12,281,297.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 51,455,375.52 | 46,683,532.64 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 399,282.09 | 30,547,801.23 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 9,547,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 9,547,900.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 399,282.09 | 20,999,901.23 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 399,282.09 | 20,999,901.23 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,306,896.36** | **1,404,671.28** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3,306,896.36 | 1,404,671.28 |
| 225101 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/ | 3,306,896.36 | 1,404,671.28 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(54,910,428.32)** | **(86,789,230.94)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(54,910,428.32)** | **(86,789,230.94)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **688,725,200.00** | **820,090,600.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **688,725,200.00** | **820,090,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 665,471,300.00 | 765,787,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 665,471,300.00 | 765,787,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23,253,900.00 | 54,302,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23,253,900.00 | 54,302,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **705,249,324.74** | **860,869,134.93** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **705,249,324.74** | **860,869,134.93** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **704,850,042.65** | **830,321,333.70** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 537,510,735.74 | 630,054,037.93 |
| 210101 | Үндсэн цалин | 359,120,321.97 | 410,300,033.22 |
| 210102 | Нэмэгдэл | 152,121,964.71 | 161,789,696.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 25,131,283.99 |
| 210104 | Урамшуулал | 26,268,449.06 | 32,833,024.33 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 67,212,400.00 | 78,350,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,704,400.00 | 53,148,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,377,000.00 | 6,300,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,688,500.00 | 3,150,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,688,500.00 | 3,150,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,754,000.00 | 12,601,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,254,617.91 | 23,302,898.77 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,538,416.63 | 8,265,355.03 |
| 210302 | Түлш, халаалт | 7,560,916.28 | 8,829,063.74 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,155,285.00 | 6,208,480.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 58,305,225.00 | 64,593,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 58,305,225.00 | 64,593,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,600,000.00 | 10,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,600,000.00 | 10,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,789,000.00 | 2,057,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,789,000.00 | 2,057,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,178,064.00 | 21,963,697.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,750,864.00 | 16,703,897.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,427,200.00 | 5,259,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **399,282.09** | **30,547,801.23** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 9,547,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 9,547,900.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 399,282.09 | 20,999,901.23 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 399,282.09 | 20,999,901.23 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(16,524,124.74)** | **(40,778,534.93)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (16,524,124.74) | (40,778,534.93) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 64,470,814.30 | 47,946,689.56 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 47,946,689.56 | 7,168,154.63 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | - | - | 1,655,522,625.07 | 1,655,522,625.07 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (54,910,428.32) | (54,910,428.32) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **1,600,612,196.75** | 1,600,612,196.75 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **1,600,612,196.75** | 1,600,612,196.75 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 6,477,042.00 | 6,477,042.00 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (86,789,230.94) | (86,789,230.94) |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **1,520,300,007.81** | 1,520,300,007.81 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | **-** | **47,946,689.56** | **-** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **809,204,800.00** | **806,566,334.93** | **2,638,465.07** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **809,204,800.00** | **806,566,334.93** | **2,638,465.07** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **799,656,900.00** | **797,018,434.93** | **2,638,465.07** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **630,054,100.00** | **630,054,037.93** | **62.07** |
| 210101 | Үндсэн цалин | 429,597,000.00 | 410,300,033.22 | 19,296,966.78 |
| 210102 | Нэмэгдэл | 178,946,100.00 | 161,789,696.39 | 17,156,403.61 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 25,131,283.99 | (25,131,283.99) |
| 210104 | Урамшуулал | 21,511,000.00 | 32,833,024.33 | (11,322,024.33) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **151,500,600.00** | **117,621,107.54** | **33,879,492.46** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,148,500.00 | 53,148,500.00 | - |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,300,500.00 | 6,300,500.00 | - |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,150,300.00 | 3,150,300.00 | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,150,300.00 | 3,150,300.00 | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,601,000.00 | 12,601,000.00 | - |
| **2105** | **Нормативд зардал** | **66,441,600.00** | **64,593,000.00** | **1,848,600.00** |
| 210502 | Хоол хүнс | 66,441,600.00 | 64,593,000.00 | 1,848,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,846,900.00** | **2,057,100.00** | **789,800.00** |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 2,846,900.00 | 2,057,100.00 | 789,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **21,963,700.00** | **21,963,697.00** | **3.00** |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,703,900.00 | 16,703,897.00 | 3.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,259,800.00 | 5,259,800.00 | 3.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **49,487,400.00** | **45,172,320.00** | **4,315,080.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,547,900.00 | 9,547,900.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,547,900.00 | 9,547,900.00 | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,556,861,200.00** | **1,474,340,000.00** | **82,521,200.00** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,466,902,500.00 | 1,466,902,400.00 | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,466,902,500.00 | 1,466,902,400.00 | 100.00 |
| | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **807,869,600.00** | **807,869,600.00** | **82,521,100.00** |
| | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 763,294,800.00 | 763,294,800.00 | - |
| | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 44,574,800.00 | 44,574,800.00 | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 47,946,689.56 | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 7,168,154.63 | -- |

### 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **54,302,800.00** | **54,302,800.00** | **20,999,901.23** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **54,302,800.00** | **33,302,898.77** | **20,999,901.23** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **54,302,800.00** | **33,302,898.77** | **20,999,901.23** |
| **2103** | **БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ** | **44,302,800.00** | **23,302,898.77** | **20,999,901.23** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,371,200.00 | 8,265,355.03 | 3,105,844.97 |
| 21302 | Түлш халаалт | 22,573,600.00 | 8,829,063.74 | 13,744,536.26 |
| 21303 | Цэвэр, бохир ус | 10,358,000.00 | 6,208,480.00 | 4,149,520.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **53,660,400.00** | **50,471,343.92** | **3,189,056.08** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,000,000.00** | **10,000,000.00** | **-** |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 10,000,000.00 | **-** |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | **-** | **20,999,901.23** | **(20,999,901.23)** |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 20,999,901.23 | (20,999,901.23) |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 58.0 сая төгрөгийн зөрчил[1] илэрснээс 58.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүллээ.

### 3.1 Албан шаардлага

1. Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс 3.1 сая төгрөгийн өөр нэр төрлийн бараануудыг тайлант хугацаанд гүйцэтгэлээр худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих гэж заасантай нийцэхгүй байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны тэмдэглэл ирүүлээгүй, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг гишүүн тус бүр баталгаажуулаагүй, 54.9 сая төгрөгийн хүнсний материал худалдан авах гэрээг байгуулахдаа нийлүүлэх хүнсний барааны жагсаалт, нэгжийн үнийг хавсаргаагүй, тухайн багцын төсөвт өртгийг /гэрээний үнэ/ гэрээнд тусгаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.1-д Гэрээний үнэ, 39.3.2-т Гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, 48 дугаар зүйлийн 48.4.6-д Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл зөвлөмж, НББ тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно, 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэснийг мөрдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн бараануудыг тайлант хугацаанд гүйцэтгэлээр худалдан авсан | 1 | 3,103.5 | | | 1 | 3,103.5 | | | | | | |
| Худалдан авалтын гэрээнд гэрээ байгуулах нийт үнэ, нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалт хавсаргаагүй гэрээг дүгнэж акт үйлдээгүй байна. | 1 | 54,900.0 | | | 1 | 54,900.0 | | | | | | |
| **Дүн** | **2** | **58,003.5** | | | **2** | **58,003.5** | | | | | | |